



22120203



International Baccalaureate®
Baccalauréat International
Bachillerato Internacional

MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1

Thursday 10 May 2012 (morning)

Jeudi 10 mai 2012 (matin)

Jueves 10 de mayo de 2012 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.
- The maximum mark for this examination paper is [25 marks].

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est [25 points].

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.
- La puntuación máxima para esta prueba de examen es [25 puntos].

Доорх хоёр зохиолын аль нэгийг сонгон тайлбарлаж бич.

1.

Мандуул хаан, Баянмөнх болох жонон хоёр, эе захаа нэгдэн, зургаан түмнийг мэдэж явав. Мандуул хаан хоёр хатантай ажгуу. Их хатан нь ойрад Бэгэрисүн тайжийн охин их хамарт Юншин, бага хатан нь Энгүд Чоросбай Төмөр чинсангийн охин Мандухай сэцэн хатан буюу. Тэндээс Мандуул хаан таван он болохуйяа дөчин 5 хоёрныхоо гахай жил халив.

Баянмөнх болох жонон Хотаханд дэрстэй нэрт газар суухад Шихир тайхугаас Даян хааныг хөвгүүлэв. Даян хааныг Балхагчиний Багай нэрт хүнд өгөв. Түүний хойно Ойрадын Ислан тайш довтолж Шихир тайхуг аваад, мөн Ислан тайш асрав. Болох жонон, Борбухын газар Булудай хоёул дутааж явтал Еншөөвийн 10 захын улсад хүрч жонон хээр байж, Булудайг үг ав гэж илгээв. Булудайн эгч нь золгож дүүгээ барьж эс тавив. Жонон умдаасаж хүлцэн ядаад, айлд бууж айраг уухад нэгэн баяд охин унгийн унасан цагаан шаргал морь, өмссөн хэрмэн дотортой монгол дээл, алтан бүс тэр бүгдийг атаалж (ажиглаж) суув. Жононг мордож эчсэний 15 дараа тэр охин усны дэргэд олон хүн байхыг үзээд эчиж хэлэв. Тийм атаатай нэгэн хүн эчив гэв. Еншөөвийн таван отгийн Хэрээ, Цагаан хоёр, Төмөр, Мөнх, Хар Бадай эд бүгдээр гүйцэж жононгоос “Чи юун хүн бэ?” гэж асуув. “Жуулчин” гэв. “Алтан бүсээ ац!” гэв. Эс өгөв. Еншөөвийн хэдэн хүн Баянмөнх болох жононг цулбуурдаж бариад хороож, барс жил тэнгэр болов. Еншөөвийн нэгэн гэм тэр гэх.

Даян хааныг муухай тэжээхэд Тангудын төлөгчийн долоо дахь хөвгүүн 20 Төмөрхадаг ирж Багайд өгүүлрүүн: “Энэ хөвгүүнийг сайн хүнд өг. Эс бөгөөс над ац.” гэж гуйж, эс өгтөв. Түүний хойно Төмөрхадаг ах дүү долуулаа сайн улаан морион үнаж ирээд, булааж авч ирэв. Өчүүхнээс эцэг эхээсээ хагацсанаар Даян хаан бэтэг өвчтэй болсон ажгуу. Тэр өвчнийг Төмөрхадагийн эм Сайхай хэмээх нь, есөн томи цагаан тэмээний сүүгээр тэжээж, гурван мөнгөн аяга цоортол илэн эмлэв (эмчлэв). 25 Тэр эмлэгээнд замаг мэт долоон хэсэг өвчин үнаж сайн болов. Даян хааны нэг зовсон тэр буй.

Түүний хойно Даян хааныг тангудын Төмөрхадаг аваачиж Мандухай сэцэн хатны гарч хүргэв.

Мандухай сэцэн хатан эртний хаадын өшөөг дурдаж үхэр жил цэрэгт 30 мордон, явган цэргийг явуулж, гурав хоносны хойно морьт цэргийг авч мордов. Мандухай сэцэн хатан нь, сайвраар саадаглаж, сандарсан үсээ хурааж (эр хүн шиг зэвсэглэн, үсээ эвхэж), сайн Даян хааныг үхэглэж (үхэг тэргэнд суулгаж) мордов. Тэр цагт Даян хаан балчир байв. Хишигтэний Алайдунгаар газарчлуулж дөрвөн түмэн ойрадыг довтлоход сэцэн хатны малгай нь үнаж, хүзүүнд эгэлдэрлэж явахад 35 ойрадын хүн үзээд, “Хатны малгай үгүй, аль” гэж өөрийн малгайгаа хатанд өгөв. Хатан аваад хориглож давшуурлаж дөрвөн түмэн ойрадыг дагуулав.

Түүний хойно Мандухай сэцэн хатанд, Хорчины Ноёнболд ун: “Галыг чинь цахиж, нутгийг чинь зааж өгсү (гэргий болгож авья)!” гэв. Мандухай сэцэн хатан зарлиг болруун: “Хааны минь өвийг Хасарын үр ч идэх буюу. Хасарын үр 40 чиний өвийг бид идэх бил үү. Өргөж үл болох үүдтэй билээ. Алхаж үл гарах босготой билээ. Хааны минь үр байтал чамд үл эчим!” гэв. Түүний хойно Сатай доголонгоос үг асууруун: “Ноёнболд унгийн үг зөв буюу, буруу буюу?” гэж асуув. Сатай доголон: “Зөв байнам. Эч.” гэв.

- Хойно хурладын Мэнд өрлөгийн гэргий Жиган Агагаас мөн урьд үг асуув.
- 45 Жиган Ага өгүүлрүүн:
- Хасарын үрд эчихүл хар мөр удирдан
 Хамаг улсаасаа хагацаж хатан нэрээ алдаю.
 Хааны үрд эчихүл хаан тэнгэрт ивээгдэж
 Хамаг улсаа эзлэн хатан нэрээ алдаршью.
 50 Цагаа хөвүүнд (цагаат хүнд) эчихүл цагаан мөр татаж
 Цахар түмнийг эзэлж цаглашгүй нэр алдаршью.
 Жиган Ага энэ үгийг айлтгав. Мандухай хатан, Жиган Агагийн үгийг зөвшөөж,
 Сатай доголонгийн үгийг буруушааж:
 55 Хааны үрийг өчүүхэн гэж
 Хамаг улсаа эзэнгүй гэж
 Хатан биеийг минь бэлбэсэн гэж
 Хасарын үрийг их гэж
 Хааш үг өгүүлмүй хэмээгээд халуун цайг тэргүүн уруу нь асгав.

Зохиогч нь тодорхойгүй, *Мандухай сэцэн хатны домог*

- Зохиолын энэ хэсгийн хэл найруулгын онцлогийг тайлбарлан бич.
- Зохиолын энэ хэсэгт юуны тухай дүрсэлснийг тайлбарла.
- Зохиогч Мандухай цэцэн хатны дүрийг хэрхэн дүрсэлсэн байна вэ?

2.

- Хүндэт Өэлүн хатны
 Хүний махаар тэжээсэн
 Хүчит Хасар гэдэг
 Хүү нь тэр мөн.
 5 Гурван бухаар зүтгүүлэвч
 Гулзайхгүй хүчтэй
 Гунжин үхрийг идэвч
 Цадахгүй ходоодтой
 Хэдэн алд биедээ
 10 Хэлхээ хуяг өмссөн
 Хэрцгий догшин Хасар
 Хэн бүхнийг идэхээр айсуй!
 Хоромсого саадагтай хүнийг
 Ховх татаад залгихад
 15 Хомхой тэр Хасарын
 Хоолойд тордоггүй гэнэ.
 Амьд бүхнийг бүхлээр
 Авч шүүрээд залгихад
 Аюулт тэр гайхлын
 20 Аманд тээглэхгүй гэнэ.
 Уур нь их хүрч
 Урдах сумаа шүүрч
 Ухасхийн харвахад
 Уулсын цаадах хүмүүс ч
 25 Уул суманд оногдож
 Ундуй сундуй үхэцгээнэ.
 Хилэн нь их хүрч
 Хийсвэр сумаа шүүрч
 Хийн зүг харвахад
 30 Хярын цаадах хүмүүс ч
 Хяргах тэр суманд
 Хядагдаж олноор үхэцгээнэ.
 Их дэлж харвавал
 Есөн зуун алд газар харвадаг.
 35 Татуу дэлж харвавал
 Таван зуун алд газар харвадаг.
 Хүнтэй адил хүн биш
 Хүнийг идэх мангас
 Хүчит Хасар тэр
 40 Хүрч ирж явна.

Зохиогч нь тодорхойгүй, *Монголын нууц тоөчоо*

- Шүлгийн хэсэгт уран дүрслэлийн ямар аргыг хэрэглэсэн байна вэ?
 - Шүлгийн хэсгийн бүтцийн онцлогийг тайлбарлан бич.
 - Шүлгийн энэ хэсгийн агуулга, утга санааг тайлбарла.
-